



**ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛИЙН  
ДУНДГОВЬ АЙМАГ ДАХЬ САЛБАР ЗӨВЛӨЛИЙН  
ТОГТООЛ**

2022 оны 04 сарын 21 өдөр

Дугаар 18.

Мандалговь

**Ж.Батдэлэгийг Шүүхийн Тамгын газрын  
Шүүх хуралдааны нарийн бичгийн даргын  
албан тушаалд нэр дэвшүүлэх тухай**


Төрийн албаны зөвлөлийн 2019 оны 14 дүгээр тогтоолоор баталсан “Төрийн албаны тусгай шалгалт өгөх болзол, журам”-ын 7 дугаар зүйлийн 7.2 дахь заалт, Төрийн албаны зөвлөлийн 2019 оны 59 дүгээр тогтоолоор батлагдсан “Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлийн ажиллах журам”-ын 3 дугаар зүйлийн 3.5.4 дэх заалт, Төрийн албаны зөвлөлийн тус аймаг дахь салбар зөвлөлийн 2022 оны 5 дугаар хуралдааны шийдвэрийг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

Нэг. Аймгийн Шүүхийн Тамгын газрын шүүх хуралдааны нарийн бичгийн даргын албан тушаалд томилогдох ажилтны сонгон шалгаруулалтад Жамъяангийн Батдэлэг 68.3 оноогоор тэнцсэн тул тухайн албан тушаалд нэр дэвшүүлсүгэй.

Хоёр Ажлын байрны шаардлагыг хангаж байгаа Ж.Батдэлэгийн холбогдох материалыг томилох эрх бүхий албан тушаалтанд хүргүүлэхийг салбар зөвлөлийн ажлын албанд даалгасугай.

ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН  
ГҮЙЦЭТГЭГЧ Ш.ТӨРБАТ





**Шүүхийн Тамгын газрын шүүх хуралдааны  
нарийн бичгийн даргын албан тушаалд нэр дэвшүүлсэн  
Ж.Батдэлэгийн тухай дүгнэлт**

1. Ж.Батдэлэг нь 1994 онд Дундговь аймгийн Сайнцагаан суманд төрсөн. 28 настай, эрэгтэй
2. Боловсрол: 2012-2016 онд Их Засаг Олон улсын их сургуулийг Олон улсын эрх зүйч мэргэжлээр бакалаврын зэрэгтэй суралцаж төгссөн.
3. Ж.Батдэлэгийн тухайн ажлын байрны ерөнхий болон тусгай шаардлагыг хангаж байгаа болон тухайн албан тушаалын сонгон шалгаруулалтад тэнцсэн зэргийг харгалзан Шүүхийн Тамгын газрын шүүх хуралдааны нарийн бичгийн даргын албан тушаалд томилуулах санал, дүгнэлтийг гаргаж байна.

ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛИЙН САЛБАР ЗӨВЛӨЛ